



БАТЛАВ ХАТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА **С. ЭРДЭНЭБОЛД**



**ХАТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2020 оны 04 дүгээр сарын 16-ний өдөр

**Төслийн нэр: “ДОТУУР БАЙРНЫ ГАЛ ЗУУХЫГ ҮДИЙН ЦАЙНЫ БАЙР БОЛГОН
ЗАСВАРЛАХ” АЖЛЫН ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Төслийн дугаар: ХБ-НТШ-2020/03

Дорнод аймгийн Хатанбулаг сумын
Засаг даргын тамгын газар 203 тоот
Засаг даргын бичигт гэсэн ажилбар бүртгэл
Утас: 80173081, 95514343
И-мэйл: xdb@bandi.gov.mn

Хатанбулаг сум
2020 он

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо¹ : 2020.04.16

Тендер шалгаруулалтын нэр: Дотуур байрны гал зуухыг үдийн цайны байр болгон засварлах

Тендер шалгаруулалтын дугаар: ХБ-НТШ-2020/03

[Хатанбулаг сумын ЗДТГ] эрх бүхий тендерт оролцогчдоос **[Дотуур байрны гал зуухыг үдийн цайны байр болгон засварлах]** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **[50,000]** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[30]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Төсөвт өртөгийн 60%-иас дээш

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Төсөвт өртөгийн 80%-иас дээш

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оноор

Сүүлийн 1 жилд хэрэгжүүлсэн 2-3 ижил төстэй ажлын өртөг нь төсөвт өртөгийн 80 хувиас дээш байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм Барилга угсралт, цахилгаан сантехникийн тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт **[1,960,000]** төгрөгийн дүнтэй 2%-ийн тендерийн баталгаа⁴ ирүүлнэ.

Тендерийг **[2020.05.18-ны 10:00]**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **[2020.05.18]-ны өдрийн, [10:30]**–т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх:⁶ **Үгүй**

Дотоодын давуу эрх тооцох эсэх.⁷ Тийм

Үнийн саналд Захиалагчийн хяналтын зардал 1,655,006 төгрөг, зохиогчийн хяналтын зардлыг Захиалагчийн хяналтын зардлын 50-иар, засварын ажлын зураг төслийн үнэ 3,310,000 төгрөгийг тус тус тусгаж ирүүлнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг www.tender.gov.mn хаягаар авч болно.

Дорноговь аймаг Хатанбулаг сумын
Засаг даргын тамгын газар 203 тоот
Засаг даргын орлогч гэсэн хаягаар ирүүлнэ.
Утас: 89173003,95514343
Имейл:zulchimedtseren@yahoo.com

¹ Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

² Тендерийн баримт бичгийг түүнийг бэлтгэхэд буюу хувилж олшруулах, шуудангаар хүргэх зэрэгт зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд энэ үнээр саадгүй олгоно.

³ Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.

⁴ Барааны төсөвт өртөг 30 сая төгрөгөөс дээш бол, тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана.

⁵ Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

⁶ Гадаадын этгээдийг худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй бол “Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй” гэж бичнэ.

⁷ Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

Гэрээний төлбөрийг дараах валютаар авна. Үүнд:

№	Валютын нэр	Тус валютаар төлөх хувь	Гадаад валютын ханш /гадаад валютын нэгж хэдэн төгрөгтэй тэнцэх/	Шаардагдах гадаад валютын дүн
(а)				
(б)				

Шаардагдах урьдчилгаа төлбөр:

	Валютын нэр	Валютын дүн
(а)		
(б)		

2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
3.1.1 Үнийн санал; Ажил гүйцэтгэх тендерийн жишиг бичиг баримтын маягтаар
3.1.2 Оролцогч компанийн танилцуулга
3.1.3 Ажил гүйцэтгэх хуваарь;
3.1.4 Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
3.1.5 Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар
3.1.6 Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл
3.1.7 Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
3.1.8 Татварын тайлан /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
3.1.9 Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/
3.1.10 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт.
3.1.11 Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа хуулбарласан тохиолдолд нотариатаар баталгаажуулах.
3.1.12 Шаардлагатай голлох мэргэжилтэй ажилтан, дарга захиралын иргэний үнэмлэх, мэргэжлийн гэрчилгээний хуулбар. |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |

- | | |
|---|--|
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>1.1.1 Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/ 1.1.2 Сүүлийн 1-2 жилд гүйцэтгэсэн 2-3 ижил төрлийн ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт/; 1.1.3 Өмнө болон одоо хэрэгжиж буй гэрээний мэдээллийг маягтаар гаргаж ирүүлэх. 1.1.4 Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: “Барилга угсралт, барилгын сан техникийн тусгай зөвшөөрөлтэй байх” тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар 1.1.5 Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах зээлийн хэмжээ нь төсөвт өртөгийн 80%-иас багагүй байх. 1.1.6 2019 оны борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртөгийн 60%-иас багагүй байна. 1.1.7 Сүүлийн 1 жилд хэрэгжүүлсэн 1-2 төрлийн ажлын өртөг нь төсөвт өртөгийн 80%-иас багагүй байх 1.1.8 Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын судалгааг ирүүлэх. 1.1.9 Ерөнхий инженер нь тендерт заасан ажилтай ижил төрлийн ажил гүйцэтгэсэн байх. 1.1.10 Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна” 1.1.11 Тендерийн үнийн дүнгийн 2%-иар тендерийн баталгаа ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Хатанбулаг сум 5-р баг ЗДТГ Давхар болон өрөөний дугаар: Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2 давхарт 203 тоот өрөө Огноо: 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Хатанбулаг сум 5-р баг ЗДТГ Давхар болон өрөөний дугаар: Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2 давхарт 203 тоот өрөө Огноо: 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 10 цаг 30 минут Цаг: 10 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “багцгүй” ХБ-НТШ-2020/03</p>

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цайны барилгын засварын ажил:

А. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачдал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ. Зураг төсөлд дуран мэдэн өөрчлөлт оруулахгүй байх ба зайлиггүй өөрчлөлт оруулах шаардлага гарвал зураг төслийн автортой зөвшилцөж шийдвэрлэх.

Б. Дотуур байрны хаалга цонх, шалны шинэчлэл, бусад өрөөнүүдийн дотор заслал, дотор халаалт, цэвэр бохир ус, гэрэлтүүлгийн засварын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

Үнийн саналд зохиогчийн хяналтын зардалыг Захиалагчийн хяналтын зардлын 50 хувиар, засварын ажлын зураг төслийн үнэ 3310000 төгрөгийг тус тус тусгаж ирүүлнэ.

2. Хаалга, цонхны ажил :

Цонх нь хуванцар рамтай давхар шилтэй салхи шорооноос хамгаалсан резин хамгаалалт нь стандарт шаардлагыг хангасан байна. Дулаан дамжуулалтын эсэргүүцэл $R=0.7$ м2.град/ватт-аас багагүй байх шаардлагатай. Цонхны эргэн тойронд тэлдэг хөөсөн чигжээсээр дулаална. Цонхонд хуванцар тавцан угсарч, гадна талд усны хаялага төмөр хийж өгнө.

Хаалга, цонхыг эрх бүхий байгууллагаар захиалж хийлгэнэ. Цонхыг хуванцар жаазтай давхар шилэн багцтай сайтар битүүмжлэгдсэн тунгалаг шилтэй монгол орны цагуурын нөхцөлд тохирсон цонх байх ба цэвэр үзэмжтэй бат бөх хийж гүйцэтгэвэл зохино. Өрөөнүүдийн хаалга нь сайн чанарын модон хаалга байх ба гадна гол хаалга нь металл төмөр хаалга байна. Хаалга цонхыг хананд сайтар бэхэлж өгнө. Цонхны үй завсарыг хөөсөөр чигжиж өгнө.

Цонх хаалганы нүхний хэмжээг нарийвчлан авч захиалах шаардлагатай. Цонхны хуваалтыг зурагт заасны дагуу гүйцэтгэх. Цонхны шилний зузаан 5 см ээс багагүй байх.

Хаалга, цонхыг задалж буулгахдаа ханыг гэмтээхгүйгээр буулгах ба хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангаж ажиллах.

2. Шалны ажил :

Өрөөнүүдийн хуучин плитан шалыг хуулж гадаргууг сайтар цэвэрлэж өгнө. Өрөөнүүдэд хавтанцар плитан шалыг стандарт норм дүрмийн дагуу нааж зай завсарын чигжээсийг сайтар хийж өгнө.

Хавтанцар плитан шалны өнгийг ашиглагч байгууллагатай тохиролцож сонгож болно.

3. Дотор заслалын ажил :

Дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, тэгшилгээ, өнгөлгөөний ажилд БНБДЗ1-10-05-г мөрдөнө.

Дотор ханын заслал хийх гадаргууг сайтар цэвэрлэж технологийн дагуу гадаргууг бэлтгэсний дараа сайн чанарын замасган тэгшилгээ хийж коридоор, танхимын өрөөнүүдийн ханыг 2 метрийн түвшинд, өнгийн тосон будгаар түүнээс дээших хэсгийг н сайн чанарын цагаан өнгийн эмульсэн будгаар будна. Өнгийн тосон будаг нь үнэргүй эрүүл ахуйн шаардлага, стандарт норм хангасан байна. Шаардлагатай нөхцөлд өнгийн тосон будгийг сорьцын шинжилгээнд хамруулах.

Заслал хийж буй өрөөнүүдийн таазны гадаргууг хусаж хөндийрсөн суларсан будаг шохойг сайтар буулган цэвэрлэж технологийн дагуу гадаргууг бэлтгэсний дараа таазанд тэгшилгээ хийж цагаан өнгийн сайн чанарын эмульсэн будгаар будна.

Заслын ажлын эмульс болон тосон будгийн өнгийг ашиглагч захиалагч байгууллагатай тохиролцож сонголтыг хийж болно. Буулгалтын ажлыг хийхдээ хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангаж ажиллах бөгөөд буулгалтаас гарсан хог шороог сайтар цэвэрлэж зайлуулах. Хуучин буулгасан хаалга, цонхыг ашиглагчид хүлээлгэн өгөх.

Дотор засварын ажилд БНБДЗ.04.02-88-г мөрдөнө. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5526-2005, MNS5252:2003, MNS4584:98, MNS4584:2003, техникийн шаардлагыг хангасан байна. Цонхны амалгааны засварын ажилд БНБДЗ.04.02-88-г мөрдөнө. Цонхны дотор амалгаанд тэгшилгээ хийж цагаан өнгийн усан суурьтай будгаар будна.

3. Хар цаасан дэврийн ажил:

Хуучин хар цаасыг хуулж гадаргууг сайтар цэвэрлэсний дараа 5 см –ийн цементэн тэгшилгээ хийж битум массаар хөрсжүүлэлт хийж 1 үе чулуутай 1 үе чулуугүй бикрость хар цаасыг технологийн дагуу наана. Дэврийн гадаргууг сайтар тэгшилж өгсний дараа хөрсжүүлэлтийг хийнэ. Прапедны дотор талд сайн чанарын шавардлага, прапедны дээр цементэн зуурмагаар ус тусгаарлагч хийж өгнө. Хар цаасны ам даралтыг хар тосоор дарж өгнө.

4. Гадна фасадны ажил :

Удийн цайны барилгын гадна ханыг 10 см зузаантай хөөсөнцөр хавтангаар дулаалж шавардлага хийж суурь цавуун хөрсжүүлэгч хийнэ. Гадна хананд фактуран өнгөлгөө хийж дунд зэргийн ширхэгтэй чулуун будгаар будна. цонх хаалганы амалгааны хуурай будаг шохойг сайтар хусаж цэвэрлэн замасган тэгшилгээ болон хөрсжүүлэгч хийж сайн чанарын усан эмульсэн будгаар будна. Мөн хөндийрсөн шаварыг буулгаж нөхөөс шавардлага хийнэ.

Гадна цоколын хананд шаварлагын засвар, тэгшилгээ хийж жижиг ширхэгтэй чулуун будгаар будна. Барилгын эргэн тойронд бетон хаявчийг 1 метрийн өргөнтэй 10 см

зузаантай бетон дэвсгэр үе хийж цементэн өнгөлгөө хийнэ. Гадна фасадны өнгийг зураг төсөлд заасны дагуу хийх бөгөөд ашиглагч талын саналыг зөвшилцөж болно.
Буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар хангаж ажиллах ба буулгалтаас гарсан хог шороог сайтар цэвэрлэж хог хаягдлыг зайлуулах.

6. Дотор гэрэлтүүлгийн ажил:

Цахилгаан мантожийн угсралтын ажлыг гүйцэтгэх үед БНБД3.05.06-90-г мөрдлөг болгоно. Цахилгааны холболтын ажилд ППВ-3х3.5мм², ППВ- 2х2.5мм² маркийн зэс голтой утас хэрэглэж хучилтын хавтанд сувлэж далд сувлэнэ.Цахилгааны материалууд нь чанартай стандартын шаардлага хангасан байна.

Хятад улсад үйлдвэрлэсэн цахилгааны мантажийн утас хэрэглэхийг хориглоно. Дотор цахилгааны утасыг сувлэн ажлыг угсралтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Унтраалга разеткийг шалны төвшнөөс дээш 1.2-1.5 метрт угсарна. Хамгаалагдсан нэг туйлт буюу хоёрлосон унтраалга, газардуулгын контакттай буюу хамгаалалттай разетка зэрэг нь чанартай стандартын шаардлага хангасан байна.

Өрөөнүүдийн хана таазанд хатгаалалттай лед гэрэлтүүлэгч, хэмнэлттэй компакт гэрэлтүүлгийг угсарна. Тус гэрэл нь станртын шаардлага хангасан чанартай байна.

Засварын ажлыг зураг төслийн дагуу чанартай хийж гүйцэтгэх.

7.Дотор халаалтын ажил

- Дотор дулааны шугамын холболтыг гүйцэтгэхдээБНБД 81-18-06, БНБД – 81-19-06, БНБД 3.05.01-88 - г мөрдлөг болгоно.

- Халаалтын шугам нь дээгүүр, доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал системтэй байна. Халаалтын системийн магистрал шугамыг 1-р давхрын шалан дээгүүр ил угсарна.

Хоолойн дулаалгын материалын дулаан дамжуулалтын коэффициент нь $\lambda=0.035$ вт/м^{°С} байх ба түүнтэй адилтгах материалыг хэрэглэнэ. Барилгын халаах хэрэгсэл нь МО140 ширмэн радиатор байна. Халаах хэрэгслийг хананд хөдөлгөөнгүйгээр бэхлэх шаардлагатай.

Шугам хоолойг холбох хэрэгслээр хийж өгөх буцах шугамд хаалт хийж өгнө. Хаалт, шугам хоолой бусад тоноглолыг чанартай материал сонгон хэрэглэх ба хийж гүйцэтгэсний дараа усаар шахаж шалгах шаардлагатай.

- Барилгын халаалтын системийн засвар үйлчилгээг хийхэд тохиромжтой байдлаар гүйцэтгэнэ.

Халаалт агаар сэлгэлт ба кодичонер БНБД 41-01-11, БНБД 40-01-02, дотор сантехникийн систем БНБД 3.05.01-88 баримталж ажлыг гүйцэтгэвэл зохино.

2. Дотор цэвэр, бохир усны ажил:

- Дотор цэвэр, бохир, усны системийн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 40-05-98-г мөрдлөг болгоно.

- Цэвэр хүйтэн усны шугамыг цайрдсан ган ГОСТ 3262-75 болон хөнгөн цагаан голчтой хуванцар хоолойгоор, бохир усыг сайн чанарын хуванцар хоолойгоор дамжуулан бохир усны төвлөрсөн шугамд холбоно. Бохир усны шугамыг сууринд дулаалгын материалаар ороож угсарна. Цэвэр усны шугам сүлжээний бөмбөлгөн хаалтууд болон холбох хэрэгсэл тоноглол зэргийг сайн чанарын материалаар хийж гүйцэтгэх ба ил явж байгаа цэвэр, бохир усны шугам хоолойн бэхэлгээг сайн хийх шаардлагатай. Шаазан суултуур, угаагуу нь чанарын шаардлага хангасан сайн чанарыг сонгон хэрэглэх.

Тендерг шалгарсан гүйцэтгэгч нь Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал „Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ,, лабораторийн шинжилгээний дүн, падаан хавсаргана.

Угсралтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуульд заасны дагуу чанарын баталгааг гаргаж өгнө.

Хэрвээ засвар шинэчлэлийн ажилд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс ажлын 3 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд төсөвт заасны дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

Үнийн саналыг тооцож ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлэх. Үнийн саналд Барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “ГҮ”81-95-12-г мөрдлөг болгоно. Үнийн саналыг батлагдсан төсвийн программаар зохиож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулна.

Автотээврийн зардлыг Зам тээврийн яамны сайдын 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар, машин механикмын зардалыг ЗТБХБ-ын Сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар батлагдсан жишиг тарифаар тус тус тооцож ирүүлнэ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сум Үдийн цайны барилгын засварын ажил

2019/11/24

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Буулгах ажил			
1	Тоосгон хананы хаалга цонхны хайрцаг задлах, шавардлагыг ховхлох	ш	20.00
2	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	342.35
3	Хуучин будагтай таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	206.10
4	Вааран хавтанцараар хийсэн ханын өнгөлгөөг буулгах	м2	103.71
5	Шалны алаг чулуун хавтанцрыг задлаж буулгах	м2	206.10
6	Хуйлмал материалан дээвэр буулгах	м2	271.20
7	Тоосгон хана, таазны суларсан шаврыг ховхолж унагах	м2	48.65
02. Хаалга цонхны ажил			
8	Гадна дотор тоосгон хананд 3 м2 хүртэл талбайтай хаалга усрах	м2	14.91
9	Гадна дотор тоосгон хананд 3 м2 дээш талбайтай хаалга усрах	м2	0.00
10	2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	1.00
11	3.6м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	1.00
12	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м2	14.91
13	Хаалганд цоож суулгах	ш	8.00
14	2м2 хүртэл талбайтай давхар шилэн багцтай хуванцар рамтай вакуум цонх угсрах	м2	1.08
15	2м2 дээш талбайтай давхар шилэн багцтай хуванцар рамтай вакуум цонх угсрах	м2	22.68
16	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	23.76
17	Цонхонд хуванцар тавиур суулгах	м2	6.65
18	Цонхонд усны хаялага төмөр салгаж буцааж угсрах	м2	8.60
03. Шалны ажил			
19	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	206.10
20	Шаланд плитан хавтанцар наах	м2	206.10
04. Дээврийн ажил			
21	Дээврийн 15мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	271.20
22	Дараагийн 1мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	м2	4,068.00
23	Битум массаар дээврийг бүрэх	м2	271.20
24	Налуу дээврийг 1 үе чулуутай 1 үе чулуугүй бикро элет хар цаасаар хийх	м2	271.20
25	Пропедны ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	48.44

Дорноговь аймгийн Хатанбулаг сум Үдийн цайны барилгын засварын ажил

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
26	Прапедний дээр хэвтээ ус тусгаарлагч шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	м2	27.68
27	Барилгын борооны усны хоолойг иж бүрнээр нь солих ф-100мм	м	20.40
05. Дотор заслал			
28	Дотор хана таазанд шаврын засварыг цементэн зуурмагаар хийх	м2	48.65
29	Хананд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	79.54
30	танхим, коридоорийн ханыг 2 метрийн түвшинд сайн чанарын тосон будгаар будах	м2	159.10
31	Угсармал хавтгаалжин таазанд заслал хийх	м2	206.10
32	Таазанд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	206.10
33	Плита наах ханыг цемент шохойн зуурмагаар гараар шавардах	м2	103.71
34	Дотор хананд 200х300мм-ийн өнгөлгөөний хавтанцар наах	м2	103.71
35	Амалгаанд шавардлагын засварыг 20мм зузаан цементэн шохойн зуурмагаар хийх	м2	29.78
36	Амалгаанд тэгшилгээ хийж сайн чанарын усан суурьтай будгаар будах	м2	29.78
06. Дотор халаалт			
37	Радиатор угсрах	ЭКМ	42.47
38	d=20мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	142.00
39	d=25мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	54.00
40	d=32мм голчтой халаалтын ган яндан угсрах	м	10.00
41	Бөмбөлгөн хаалт угсрах голч d=20мм	ш	24.00
42	Вентиль угсрах голч d=25мм	ш	4.00
43	Хий хураагч тавих голч 100мм	ш	2.00
44	Халаалтын яндангийн бэлдэц бэлтгэх голч-20мм	м	142.00
45	Халаалтын яндангийн бэлдэц бэлтгэх голч-25мм	м	54.00
46	Халаалтын яндан хоолой усаар шахаж шалгах d=50мм	м	206.00
47	Халаалтын 50мм бага голчтой хоолойнууд будах	м2	53.62
07. Дотор цэвэр бохир ус			
48	d=20мм голчтой цайрдсан ган хоолой угсрах	м	4.00
49	Дотор ус хангамжийн хөнгөн цагаан голчтой хуванцар хоолой ф 15 мм	м	23.00
50	Хаах вентиль угсрах голч d=32мм	ш	1.00
51	Хаах вентиль угсрах голч d=25мм	ш	2.00
52	Хаах вентиль голч d=20мм	ш	1.00
53	Бөмбөлгөн хаалт угсрах голч d=20мм	ш	4.00
54	Бөмбөлгөн хаалт угсрах d=15мм	ком	5.00
55	Хүйтэн усны тоолуур угсрах Ф 15мм	шир	2.00
56	Цэвэр усны яндангийн бэлдэц бэлтгэх голч-20мм хүртэл	м	27.00
57	Бохир усны хуванцар хоолой d-50	м	18.00
58	Бохир усны хуванцар хоолой d-100	м	16.00
59	Хоёр тасалгаатай төмөр угаагуур тавих	1ш	1.00

Дорноговь аймгийн Хатанбулаг сүм Үдийн цайны барилгын засварын ажил

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
60	Хүйтэн, халуун усны салбар шугамтай ганцаарчилсан угаагуур тавих	ш	1.00
61	Шаазан зайлах торхтой суултуур байрлуулах	1ком	1.00
62	Угаагуурын холигч байрлуулах	ш	1.00
63	Трап угсрах голч-50мм	1ш	2.00
64	Шугам хоолой усаар шахаж шалгах d=50мм	м	45.00
65	Шугам хоолой усаар шахаж голч-100мм	м	16.00
66	Агшин зуурын ус халаагч угсрах N=3.2кВт, V=220В	ш	2.00
08. Дотор гэрэлтүүлэг			
67	Оролтын хувиарлах угсрах	ком	1.00
68	Гэрэлтүүлэгчийн самбар бэлэн нүхэнд угсрах	ком	1.00
69	2х2.5мм2 хүртэл нийлмэл огтлолтой нэг ба олон судастай 1-р утас сүвлэх	м	350.00
70	4мм2 хүртэл нийлмэл огтлолтой зэс голтой утас сүвлэх	м	130.00
71	6мм2 хүртэл нийлмэл огтлолтой зэс голтой утас сүвлэх	м	75.00
72	Хамгаалалттай лед гэрэлтүүлэгч таазанд угсрах 2х18вт	ш	18.00
73	Ус чийгнаас хамгаалагдсан гэрэлтүүлэгч таазанд угсрах	ширхэг	14.00
74	"Гарах", "Орох" гэрэлтүүлэгч угсрах	ш	3.00
75	Хамгаалагдсан нэг туйлт унтраалга угсрах 250В 6А	ширхэг	4.00
76	Ердийн нэг туйлт унтраалга угсрах	ширхэг	5.00
77	Хамгаалалттай нэг туйлт унтраалга тавих	ширхэг	3.00
78	Мөн хоёрлосон унтраалга угсрах	ширхэг	4.00
79	Газардуулгын контакттай хамгаалагдсан розетка угсрах	ширхэг	6.00
80	Розетка унтраалагын блок угсрах	ш	18.00
81	Төмөр хайрцаг тавих	ш	13.00
82	Хамгаалалтын хуванцар хар хоолойг угсрах	м	555.00
83	160мм2 хүртэл хөндлөн огтлолтой туузан төмрөөр хийсэн газардуулгын шинийг бэхлэх	м	130.00
84	40*40*4мм хэмжээтэй булан төмөр газардуулагчыг гар ажилгаагаар зоох	ш	4.00
85	8мм хүртэл голчтой бөөрөнхий төмрөөр хийсэн газардуулгын шинийг угсрах	м	260.00
09. Гадна фасад			
86	Хананд дулаалгын хөөсөнцөр цавуут зуурмагаар наагаад хадаж цавуут зуурмаг хийж тор нааж дээр нь цавуут зуурмаг, хөрсжүүлэгч хийх	м2	245.54
87	Хананд фактуран өнгөлгөө хийх / шагрей/	м2	245.54
88	Хананд дунд ширхэгтэй чулуун өнгөлгөө хийх	м2	245.54
89	Гадна амалгаа сайн чанарын усан суурьтай эмульсэн будгаар будах	м2	19.56
90	Цоколын суларсан шаврыг ховхолж унагах	м2	32.26
91	Цоколын ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	32.26
92	Цоколд жижиг ширхэгтэй чулуун өнгөлгөө хийх	м2	32.60
93	Бетон хаявч цутгах БМ 100	м3	3.60

Дорноговь аймгийн Хатанбулаг сүм Үдийн цайны барилгын засварын ажил

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
94	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	35.84
99.Хог хаягдлын дүн			
95	Хог хаягдал	тн	0.00

Техникийн тодорхойлолт боловсруулсан
Үнэлгээний хороо

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| 7. Ажлын хөтөлбөр | Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ⁸ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

⁸ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги⁹ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт

⁹ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах

бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ¹⁰

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Дорноговь аймгийн Хатанбулаг сум Дотуур байрны гал зуухыг үдийн цайны байр болгон засварлах ажил ХБ-НТШ-2020/03</i>
ГЕН 2.1	Ажил нь: <i>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Дотуур байрыг үдийн цайны байр болгон засварлах ажлаас бүрдэнэ.</i> Ажлын талбай: <i>Хатанбулаг сумын төв</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь Хатанбулаг сумын Засаг даргын орлогч З.Чимэдцэрэн
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: 2020.05.25 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2020.08.25
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[ажлын 5]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>36 сар</i> байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[1 хувь]</i> байна. ¹¹ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[2020.08.25]</i> -ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[2020.08.25]</i> -ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[400,000 төг]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[1 хувь]</i> -иар тооцно.

¹⁰ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

¹¹ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

ВАЛТАЗ

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

Үнэлгээний хорооны дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд

Ц.Сайнбуян

Ө.Мөнгөнхөлөг

Х.Мөнхжаргал

Д.Буянцэцэг

О.Содцэцэг

